# Япон улс дахь сургалт

Д.Долгорсүрэн
Ирээдүй ЦС, сургалтын менежер
2012.06.17-30

# Сэтгэгдэл



Улаанбаатар СХД-ийн "Ирээдүй" цогцолборын 1-р ахлах сургуулийн сургалтын менежер Д.Долгорсүрэн

"Багшлахуйн арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэх" төслийн хүрээнд Япон улсад 14 хоног сургалтанд хамрагдаж японы сургуулиуд болон япон багш нарын арга зүй, сургуульд суурилсан хичээлийн судалгаа, багш нарын мэргэжил дээшлүүлэх тогтолцоо зэрэгтэй танилцаж туршлага судлах, суралц ах боломж олгосон JIKA төслийн багийн хамт олонд баярласнаа илэрхийлье.

# ХИЧЭЭЛИЙН БЭЛТГЭЛ СУДАЛГАА, САМБАР АШИГЛАЛТ

Сурч мэдсэн, үзэж танилцсан зүйлээ та бүхэнтэй хуваалцаж байна.

# *Хичээл заах тухай*

- “Хичээлийн бэлтгэл судалгаа”-гаар юу хийх хэрэгтэй вэ?
- Нэгж хичээлийн явцын дагуу “хичээлээ сайжруулахдаа анхаарах 3 байр суурь
- “ Самбар ашиглалт”-г хэрхэн төлөвлөвөл дээр вэ?
- “Үнэлгээ” “үнэлгээний стандарт” “ Үнэлэлт”

# Хичээлийг улам сайжруулахад анхаарах 3 байр суурь

Зорилт (төлөвшүүлэх чадвар)-г тодорхой болгоорой.

Хичээлийн явцыг тодорхой ойлгомжтой болгоорой.

Хичээлийн зорилтын биелэлтийг гүйцэд хараарай.

## 1 цагийн хичээлд

**Эхлэл**

Зорилтыг тодорхойлох

Судлах асуудал (даалгавар)-г самбар г.м. ойлгомжтой байдлаар гаргаж харуулаарай.

**Дунд (судлах)**

Хичээлийн явцыг тодорхой, ойлгомжтой болгох

Судлах агуулгатай тохирсон аргаар судлуулах

- Гараараа хүрч
- Харьцаж
- Сэтгэн бодож
- Мэдэрч

} судлах

**Төгсгөл**

Хичээлийн зорилтын биелэлтийг гүйцэд харах

Агуулгыг давтах болон тодорхойлолтыг магадлах, гүнзгийрүүлсэн бодлогыг бодох хугацаатай болгоорой.

Эдгээр процесс нь хичээлийн өмнө явагдах хичээлийн бэлтгэл судалгаа юм.

1. Бүлэг сэдэв, хичээлийн хэрэглэгдэхүүнийг ярилцах
2. Зорилго зорилт, үнэлгээний тухай ярилцах
3. Бүлэг сэдэв ба хэрэглэгдэхүүний ач холбогдол (сайн тал) болон нэгдмэл байдал, агуулга, зарчмыг тодорхой болгох. Математик агуулга, математик сэтгэлгээний тухайд яг юуг тухайлан авч үзэх вэ гэдгээ зөвлөлдөх
4. Сурагчдын бодит чадварыг илрүүлэх
5. Дидактик алхмуудаа төлөвлөх, ярилцах

# Хичээлийн бэлтгэл судалгаа гэж

- Хүүхдүүдийн бодит байдал
- Зорилт болон сургах агуулга
- Материалын судалгаа гэсэн

3 зүйлд тулгуурлан сургалтын материалыг тодорхойлж , хичээл заах аргыг төлөвлөх үргэлжилсэн явцыг хэлдэг.

# Хүүхдүүдийн бодит байдал



Сонирхож буй зүйл, анхаарлаа хандуулдаг зүйл нь юу вэ?



Өмнөх цаг хүртэл юуг судалж ирсэн бэ?



Хүүхдийн юмыг бодох арга болон тухайн агуулгыг судлах аргын онцлог нь юу вэ?



Найз нөхөд болон багштайгаа хэрхэн харилцдаг вэ

# Материалын судалгаа

- Боловсролын стандартын зорилгыг биелүүлж чадах эсэх
- Хүүхдүүд судлахад сонирхолтой байх эсэх
- Өмнө судалсан агуулгыг ашиглах боломжтой эсэх
- Хүүхдүүд өөрсдөө бие дааж судлах боломжтой эсэх
- Өдөр тутмын амьдралтай холбоотой эсэх
- Цаашид гүнзгийрүүлэн судлах боломжтой эсэх



# Хүүхдүүдийн бодит байдал, материалын судалгаанд тулгуурлан зорилтыг хангах хичээлийг зохион байгуулах төлөвлөгөө зохионо.

- Материалыг ямар байдлаар судлуулахыг шийдэх
- Хичээлийн явц
- Хичээлийн хэлбэрийг тодорхой болгох /ганцаар, группээр, ангиараа судлах/
- Судалгааны ажилд хүүхэд тус бүрийн бодолыг тусгасан байх
- Хичээлийн төгсгөлд бий болох хүүхдийн төлөвшлийг тодорхойлох

Хичээлийн 1 цаг
45 минут

Ердийн хичээл нь

- Эхлэл хэсэг, сэдэлжүүлэлт 5-10 мин
- Өрнөл хэсэг 25-30 мин
- Дүгнэлт 15-20 мин

гэж хуваарилах ба эхлэл, өрнөл, дүгнэлт хэсэг тус бүрийн багшаас асуух асуултыг боловсруулах, хүүхдээс ирэх хариултыг тооцох, эдгээрийг хичээлийн хөтөлбөрт тусгасан байх

*“**Зорилт** (төлөвшүүлэх чадвар)-г тодорхой болгох” гэж юу гэсэн үг вэ?*



# *Хүүхдүүдэд хичээлийн зорилтыг ойлгуулахын тулд* …

- Бодит зүйл дээр ажиллуулах, зураг зуруулах, ажлын хуудас дээр өөрийн санаа бодлыг бичүүлэх, санаа бодлоо хоорондоо ярилцах гэх мэт....
- Судлах асуудал (даалгавар)-г самбарын анхаарал татахуйц газар бичих
- Судлах асуудал (даалгавар)-г хүүхдүүдтэй хамт унших, дэвтэрт бичүүлэх цаг гаргах

# Зорилтыг тодорхой болгохын тулд ...

1. Боловсролын стандартад заасан тус бүрийн судлагдахууны зорилт болон судлах агуулгыг тодорхойлох
2. Өмнөх цаг хүртэл хүүхдүүдийн бодит байдлыг тодорхойлох
3. Мэдлэг болон ур чадвар төлөвшүүлэх, эсвэл сэтгэн бодох чадвар, асуудал шийдвэрлэх чадвар, илэрхийлэх чадвар г.м-ийг тодорхойлох

## *Зорилтыг тодорхойлж хичээлээ төлөвлөхийн тулд ...*

1. Тодорхойлсон хичээлийн зорилгын дагуу хичээлийн төгсгөлийн үеийн хүүхдүүдийн төлөвшлийн байдлыг төсөөлөх
2. Тийм байдалд хүргэхийн тулд хичээл дээр ямар асуудал (даалгавар)-г судлуулж, ямар үйл ажиллагааг хийлгэвэл зохихыг бодох
3. Зорилтын дагуу ямар үгээр дүгнэлт хийж самбар дээр бичихийг төлөвлөх

# Бодит зүйл дээр ажиллуулах

Хэний тарьсан цагаан будаа сайн ургасан бэ












全ての撮影日






3
うでずもう
コーナー
勝負しよう！










どんなふうに手提げを持つ？



## Судлах асуудал (даалгавар)-г самбарын анхаарал татахуйц газар бичих





## Судлах асуудал (даалгавар)-г хүүхдүүдтэй хамт унших, дэвтэрт бичүүлэх цаг гаргах





"Гараараа хүрч" "харьцаж" "сэтгэж бодож" "мэдэрч" ...

"Хичээлийн тодорхой, ойлгомжтой байдал" гэж юу гэсэн үг вэ?



# Бодит зүйл болон үзэж сонсох сургалтын техник хэрэгсэл ашиглаж .....

- Бодит зүйлийг харуулах, гараараа ажиллуулж үзэх г.м-ийн үйл ажиллагааг оролцуулснаар хүүхдүүдэд шинэ нээлт хийх боломжтой.
- Зураг, фото зураг, дүрсэн бичлэг г.м-ийг үр дүнтэй харуулснаар хүүхдүүдийн судлах сонирхлыг нэмэгдүүлэх, шинэ нээлт хийлгэхэд дэмжлэг үзүүлж хүүхдүүдээр олон янзын санаа бодлыг гаргуулах боломжтой.

# Бодоорой

- "….-ын талаар судалж үзье"   "….-г турших үзье"…..
- Энд өөрийн гэсэн таамаглал, төсөөлөл, асуултыг олуулах нь чухал байна.
- Судлах агуулга (даалгавар)-н талаар хүүхдүүд өөрсдөө дүгнэлт хийх цагтай болгоорой.
- Мөн шаардлагатай бол ширээнүүдийн дундуур явж зөвлөгөө өгөөрэй.
- Зохих хэмжээгээр "бичих үйл ажиллагаа"-г оролцуулаарай.

Бодит зүйлийг харуулах, гараараа ажиллуулж үзэх г.м-ийн үйл ажиллагааг оролцуулснаар хүүхдүүдэд шинэ нээлт хийх боломжтой.









Зураг, фото зураг , дүрсэн бичлэг зэргийг үр дүнтэй харуулснаар судлах сонирхлыг нэмэгдүүлэх







# Самбар ашиглалтыг хэрхэн төлөвлөвөл дээр вэ?

# Самбар төлөвлөлт

- Нэг цагийн хичээлийн явцад самбарт хэрхэн бичих талаар бодож үзэх нь “Хичээлийн төлөвлөлт” мөн.
- Хичээлийн бэлтгэл судалгаагаар судалсан зүйлээ самбар дээр хэрхэн илэрхийлэхийг бодож үзье. Ойлгомжтой байдлаар бичигдсэн самбар нь хүүхдүүдийн ойлголтыг улам нэмэгдүүлж, сэтгэхүйг нь улам гүнзгийрүүлэхэд тус болдог.

Эхлээд нэг цагийн хичээлийн явцын дагуу самбарын хаана юуг бичих тухай авч үзье.

### Эхлэл

- Судлах асуудлын талаар төсөөлөлтэй болох

### Судлах

- Хүүхдийн санаа бодол, асуултыг тусгах

### Төгсгөл

- Хүүхдүүдийн байдлаас нь зорилт биелэгдсэн эсэхийг мэдэх

# Бас доорх зүйлд анхаараарай

- Үндсэндээ цагаан шохойгоор бичнэ. Онцлон тэмдэглэхэд шар өнгөөр бичиж, улаан ба цэнхэр өнгийг бага хэрэглээрэй.
- Хүүхдүүдэд уншихад эвтэйхэн хэмжээ болон өргөнөөр бичнэ. (заримдаа ангийн хойд талаас өөрийн бичсэн самбарыг хараарай)
- Хүүхдүүдийн үйл ажиллагааны дундуур самбарт бичихгүй байна (хүүхдүүдийн хийж буй ажилд хандуулах анхаарлыг сарниулчихна).
- Хичээлийн явцад бичсэн зүйлийг арилгахгүй, нэг цагийн хичээлийн явцыг харж болох самбартай байна.

Огноо

Судлах асуудал (даалгавар)

Найзын бодол

Ойлгосон зүйл

Энэ хэсэг чухал! Өөрийн бодлоо бичих цаг олгоорой.

Өөрийн бодол, асуулт

Дүгнэлт

Дасгал, гүнзгийрүүлсэн бодлого, өөрийн үнэлгээ, гэрийн даалгавар








Бичигдсэн самбарын дагуу дэвтрээ бичүүлэх




問題
実験
結果
予想






問題
実験
結果
予想
まとめ



хүнд = Урт
③Хариуг олох санаа
Уртын хэмжээг ашиглан хүндийн хэмжээг олцгооё
③Хариултын санаа коор/шулуун (бодолтыг үргэлжлүүлэх арга, үндэслэл)
② Бодлого
4m-тэй 6gтууз байв.
□m бол хэдэн g боох вэ
④ 14m бол
④ 28m бол
④ 28÷4=7
7дахин
6×7=42
④14mбол 4m-ийн 3.5 дахин их болох ёстой (Нэр)
дахин гэвэл тоо ширхэгийг
19-7=12
Дэвтэртээ тайлбар бичье
















## “Багшийн асуух асуулт чухал гэж хэлдэг ч ......

- Багшийн асуулт нь хүүхдийн бодлыг татаж гаргуулах, санаа бодлыг нь улам гүнзгийрүүлэхэд чухал арга болдог.
- Асуултын чанар нь хүүхдүүдийн үйл ажиллагааны байдал болон хичээлийн зорилтын биелэлтэд ихээр нөлөөлдөг.



# Ийм тохиолдол гардаг уу?





Та бүхэн ... –н талаар юу гэж бодож байна вэ?

Сэтгэгдэл ч юм уу, анзаарагдсан зүйл байгаа биз дээ?

“Юу гэж?” гэж юу гэсэн үг вэ?



За байз ..., тийм ээ ... жишээ нь “ .... байгаа нь сонирхолтой ч юм уу, “..... нь.... учраас ийм байдаг юм байна” ч юм уу....

Багш аа. Юу ярих хэрэгтэй вэ?

# Яагаад ийм байдал үүсчихсэн бэ?

## Энд 3 том асуудал байна.

1. Багш асуух гэж байгаа асуултын агуулгыг хүүхдүүдэд ойлгуулж чадаагүй.
2. Багш асуултыг өөр үгээр дахин хэлж байна. (Энэ нь хүүхдүүдийн “бүдрэхийг” урьдчилан төсөөлж өөр үгээр хэлээд байгаа биш, бараг л аргагүйн эрхэнд тэгсэн байна.)
3. Хүүхдүүдээр хэлүүлэх гэж байсан зүйлийг багш өөрөө хэлчихсэн байна.

# Асуултыг бэлтгэхэд анхаарах зүйл

Яагаад асуух гэж байгааг тодорхойлох

- Өмнө судалсан агуулгыг бататгахын тулд
- Өөрийн гэсэн санаа бодолтой болгохын тулд
- Шинэ зүйлийг анзааруулахын тулд
- Судалсан агуулгын тогтсон эсэхийг үнэлэхийн тулд гэх мэт ..........

# Асуултын жишээ:

эхлэл

Хүүхдүүдийн сэтгэлийг ойлгож асуух

- Анзаарагдсан зүйл байна уу?
- Юу хэрэглэвэл болмоор байна вэ?

Хичээлийн явцад

- Үүнтэй холбоотой санаа бий юу?
- Үргэлжлүүлээд саналаа хэлэхгүй юу?
- Үүнийг бодох өөр арга бий юу?

Ширээний дундуур явж зөвлөгөө өгөхдөө:

(хүүхэд тус бүрийн бодит байдалтай тохируулан асуух )

- Аль нь болохгүй байна вэ?
- Өмнөх цагийн хичээлд судалсан зүйлээ хэрэглэж бодвол болохгүй байх даа?

Хамтарсан судалгааны үед:

(үнэн санаанаас хандаж, толгой дохиж асуух)

- А-ийн бодлыг хэрэглэж болохгүй юу?
- 3 аргыг харьцуулж үзээд хоорондоо төсөөтэй тал байхгүй юу?

# Асуулт асуухад анхаарах зүйл

- Асууж буй агуулгыг тодорхой болгох
- Товч бөгөөд тодорхой үгээр асуултыг асуух
- Гол асуултын тоо хэт олон биш байх

Асуулт асуусны дараа “хэсэг хугацаа хүлээгээрэй”, “ Чимээгүй орчин” нь хүүхдүүдэд юм бодуулдаг юм.

## Хичээлийн төгсгөлд юу хийх хэрэгтэй вэ...

1 Хүүхдээр энэ цагт судалсан зүйлээ эргэн харах боломж олгож түүнийг өөрийн үгээр дүгнүүлээрэй.

Өөртөө гарсан өөрчлөлтийн явц, бас найз нөхдийн санаа бодлын сайн талыг олуулаарай. (харилцан үнэлгээ)

2 Дүгнэсэн агуулгаа үндэслэн, өөрийн судалсан агуулгыг бүрэн тогтоох бодлого, дасгал хийлгээрэй.

3 (Зорилтын биелэлтийг гүйцэд харах) Хүүхдүүд тус бүрийн бодит байдлыг тодорхойлоорой.

Хичээлийн зорилтын дагуу шаардлагатай бол ажлын хуудас болон суудлын байрлалын зургийг ашиглан үнэлээрэй.

# Суудлын байрлалын зураг

## /багшийн тэмдэглэл хөтлөх хуудас/



4 [Тухайн хүүхдэд тохирсон зөвлөгөө өгөх]

Үнэлгээний дагуу туслалцаа хэрэгтэ
хүүхдэд зохих зөвлөгөө өгөх
Бие дааж бодож чадах гүнзгийрүүлсэн бодлогыг бас бэлдсэн байгаарай.

"Самбарын ... г эргэж хараарай."
"…. –ийн ярьсан агуулгыг санаарай."




Судалсан агуулгыг тогтоолгоход төгсгөлийн хэсэг чухал үүрэг гүйцэтгэдэг юм шүү!

# Анхаарал тавьсанд баярлалаа.

